

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН  
2011 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
НЭГТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2011.05.10

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,  
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

2011 оны нэгдүгээр улиралд нийт 8 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 7 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 183 ББСБ-ын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдлаа.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан ББСБ-уудыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 1/

№	ББСБ-ын нэр	Эрхлэх үйл ажиллагааны нэр төрөл	Нэмэлт мэдээлэл
1	Ашидтүвшин инвест	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
2	Монгорү матрикс гинго	Зээл, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх ба 100 хувийн Японы хөрөнгө оруулалттай
3	Даймонд фаянсанс	Зээл, гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
4	Си жи эм	Зээл, факторинг, төлбөрийн баталгаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
5	Эко капитал	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
6	ТДБ секьюритис	Зээл, төлбөрийн баталгаа гаргах, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
7	Девелопинг энтэрпренюриал монголиа	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
8	Төгөл инвест	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх

Дараах нэр бүхий 7 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна:

/Хүснэгт 2/


№	ББСБ-ын нэр	Эрхлэж байсан үйл ажиллагааны нэр төрөл	Нэмэлт мэдээлэл
1	Сити хөгжил	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж, Төв аймгийн сумдын иргэдэд зээлийн үйлчилгээ хүргэж байсан
2	Арвижих хангай	Зээл, гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
3	Өнө ингүүмэл	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж

			байсан
4	Гэрэл инвест	Зээл	Орхон аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байсан
5	Обил	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
6	Шанх уул	Гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
7	Хөгжил эх	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан

Мөн хугацаанд 1 ББСБ /Жалбуутайж/-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авсан байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоог өмнөх онуудтай харьцуулвал:

/График 1/



2011 оны I дүгээр улирлын тайлант хугацааны тайлангийн нэгтгэлийн голлох статистик үзүүлэлтүүдийг харуулбал:

/Хүснэгт 3/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны I улирал	2010 оны I улирал	Өсөлт +/-, бууралт +/-
1	ББСБ-ын тоо	183	184	-1
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	564	582	-18
3	Ажиллагсадын тоо	906	850	56
4	Салбар нэгжийн тоо	69	64	5
5	Харилцагчдын тоо	73,314.0	46,456.0	26,858.0
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	142,175,513.1	106,943,599.6	35,231,913.5
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>2.1%</b>	<b>2.4%</b>	<b>-0.3%</b>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	85,169,831.5	62,421,241.1	22,748,590.4
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>2.3%</b>	<b>2.9%</b>	<b>-0.6%</b>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	101,704,588.0	79,217,698.0	22,486,890.0
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>24.8%</b>	<b>31.9%</b>	<b>-7.1%</b>
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	90,179,919.1	71,961,587.7	18,218,331.4
	<b>Банкны салбарт эзлэх хувь</b>	<b>36.7%</b>	<b>26.3%</b>	<b>0.10</b>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	6,936,372.4	5,395,174.6	1,541,197.8
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	8,670,626.7	6,326,944.4	2,343,682.3
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	7,542,203.2	5,358,007.0	2,184,196.2
13	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	1,128,423.5	968,937.4	159,486.1

1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	15	10	5
	<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>	<b>8.2%</b>	<b>4.9%</b>	<b>3.3%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	22,173,729.1	16,985,289.2	5,188,439.9
	<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>	<b>15.6%</b>	<b>15.9%</b>	<b>-0.3%</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	16,897,439.4	12,041,935.4	4,855,504.0
	<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>	<b>19.8%</b>	<b>19.3%</b>	<b>0.5%</b>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	11,933,218.1	7,371,456.2	4,561,762
	<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>	<b>11.7%</b>	<b>9.3%</b>	<b>2.4%</b>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	9,892,076.0	7,821,032.5	2,071,043.5
	<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>	<b>11.0%</b>	<b>10.9%</b>	<b>0.1%</b>
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	25	28.0	-3
	<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>	<b>13.7%</b>	<b>15.2%</b>	<b>-1.5%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	4,390,532.7	3,028,003.2	1,362,530
	<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>	<b>3.1%</b>	<b>2.8%</b>	<b>0.3%</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	5,294,950.9	3,228,456.9	2,066,494.0
	<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>	<b>6.2%</b>	<b>5.2%</b>	<b>1.0%</b>
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	4,005,051.6	2,779,771.9	1,225,279.7
	<b>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</b>	<b>3.9%</b>	<b>3.5%</b>	<b>0.4%</b>
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	3,752,613.2	2,767,567.1	985,046.1
	<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>	<b>4.2%</b>	<b>3.8%</b>	<b>0.4%</b>
3	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	46	50.0	-4
	<b>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</b>	<b>25.1%</b>	<b>27.2%</b>	<b>-2.1%</b>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	5,975,741.44	6,720,134.4	-744,393.0
	<b>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</b>	<b>4.2%</b>	<b>6.3%</b>	<b>-2.1%</b>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	5,945,344.01	6,700,990.2	-755,646.2
	<b>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</b>	<b>5.8%</b>	<b>8.5%</b>	<b>-2.7%</b>
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	5,015,993.37	6,085,661.2	-1,069,667.8
	<b>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</b>	<b>5.6%</b>	<b>8.5%</b>	<b>-2.9%</b>

**Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:**

2011 оны 1 дүгээр улирлын байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 15 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.2 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 15.6 хувийг, нийт олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 19.8 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн 11.7 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 11.0 хувийг тус тус

эзэлж байна. Тэдгээрийг гадаадын хөрөнгө оруулагчдын харьяаллаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 8, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, Итали улсын хөрөнгө оруулалттай 1, ОХУ-ын хөрөнгө оруулалттай 1 ББСБ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

**Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:**

2011 оны 1 дүгээр улирлын байдлаар орон нутагт төвтэй 25 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 13.7 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 3.1 хувийг, нийт олгосон зээл нь нийт ББСБ-ын олгосон зээлийн 6.2 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 3.9 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.2 хувийг тус тус эзэлж байна.

/График 2/



2010 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт төвтэй 26 ББСБ бүртгэлтэй байсан бол 2011 оны 1 дүгээр улиралд 1 ББСБ /Орхон аймаг-Гэрэл инвест ББСБ/-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор 25 болж буурсан байна.

**Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:**

Гадаад валютын арилжааг дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 44 ББСБ, зээл, гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрөлтэй 2 ББСБ /Арвижих тив, Батжиннэгдэх үрс / буюу нийт 46 ББСБ зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 25.1 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 4.2 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 5.8 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 5.6 хувийг тус тус эзэлж байна.

2010 оны жилийн эцсийн байдлаар нийт 48 ББСБ бүртгэлтэй байснаас 2011 оны 1 дүгээр улиралд 1 ББСБ /Шанх-Уул ББСБ/-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, Нью евро ази ББСБ /зээл, гадаад валютын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй/ зээлийн үйл ажиллагаа эрхэлснээр зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ-ын тоо 46 болж буурсан.

ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээг эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 4/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо	
		2011 оны I улирал	2010 оны I улирал
1	Зээл	136	137
2	Факторингийн үйлчилгээ	10	6

3	Төлбөрийн баталгаа гаргах	8	5
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	5
6	Гадаад валютын арилжаа	94	112
7	Итгэлцлийн үйлчилгээ	11	9
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	9	7
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ /Венчур хөрөнгө оруулалт/	1	1

2011 он гарснаас хойшхи эхний улиралд 6 ББСБ /Сити хөгжил, Арвижих хангай, Өнө ингүүмэл, Гэрэл инвест, Обил, Хөгжил-Эх/-ын зээлийн үйл ажиллагаа эрхлэх, 2 ББСБ /Арвижих хангай, Шанх-уул/-ын гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон бол, 8 ББСБ /Ашидтүвшин инвест, Монгорү матрикс гинго, Даймонд финанс, Си жи эм, Экокапитал, ТДБ секьюритис, Девелопинг энтерпренюриал монголиа, Төгөл инвест/-д зээлийн үйл ажиллагаа эрхлэх, 2 ББСБ /Монгорү матрикс гинго, Даймонд финанс /-д гадаад валютын арилжаа эрхлэх, 1 ББСБ /Си жи эм/-д факторингийн үйлчилгээ эрхлэх, 2 ББСБ /Си жи эм, ТДБ секьюритис/-д төлбөрийн баталгаа гаргах, 1 ББСБ /ТДБ секьюритис/-д богино хугацааны санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, 1 ББСБ /Монгорү матрикс гинго/-д хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг тус тус шинээр олгосон байна.

Тайлант хугацаанд 1 ББСБ /Жалбуутайж-2 дугаар сард/-ын ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авчээ.

2011 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд 6 ББСБ буюу нийт ББСБ-ын 3.3 хувь нь эхлэлтийн санхүүгийн тайлангаар, 11 ББСБ буюу нийт ББСБ-ын 6.0 хувь нь өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр тус тус хамрагдлаа.

## ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1 Активын бүтэц, өөрчлөлт:

ББСБ-ын салбарын 2011 оны 1 дүгээр улирлын тайлант хугацааны нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 5/

№	ХӨРӨНГӨ	2011.03.31		2010.03.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
<b>A</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>136,952,517.4</b>	<b>96.3%</b>	<b>102,538,526.2</b>	<b>95.9%</b>	<b>34,413,991.2</b>	<b>33.6%</b>
1	Мөнгөн хөрөнгө	42,989,295.2	30.2%	34,395,691.5	32.2%	8,593,603.8	25.0%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	1,787,459.5	1.3%	2,004,492.4	1.9%	-217,032.9	-10.8%
3	Нийт зээл	85,169,831.5	59.9%	62,421,241.1	58.4%	22,748,590.3	36.4%
	(Зээлийн эрсдлийн сан)	4,076,391.6	2.9%	3,536,753.8	3.3%	539,637.9	15.3%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	2,114,524.4	1.5%	1,080,001.9	1.0%	1,034,522.5	95.8%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%

5	Нийт факторингийн тооцооны авлага	175,840.3	0.1%	417,101.6	0.4%	-241,261.3	-57.8%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	0.0	0.0%	350.0	0.0%	-350.0	-100.0%
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	419,255.8	0.3%	389,429.1	0.4%	29,826.6	7.7%
7	Бусад хөрөнгө	8,372,702.4	5.9%	5,367,672.4	5.0%	3,005,030.0	56.0%
<b>Б</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>5,222,995.7</b>	<b>3.7%</b>	<b>4,405,073.4</b>	<b>4.1%</b>	<b>817,922.3</b>	<b>18.6%</b>
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	5,222,995.7	3.7%	4,405,073.4	4.1%	817,922.3	18.6%
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	6,968,700.5	4.9%	5,866,934.8	5.5%	1,101,765.7	18.8%
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,745,704.7	1.2%	1,461,861.4	1.4%	283,843.3	19.4%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>142,175,513.1</b>	<b>100.0%</b>	<b>106,943,599.6</b>	<b>100.0%</b>	<b>35,231,913.5</b>	<b>32.9%</b>

2011 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт актив өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар өссөн ба ийнхүү өсөхөд ББСБ-уудын үйл ажиллагааны үр дүн болох хуримтлагдсан ашгийн 37.5, нийт өр төлбөрийн 46.0 хувийн болон хувьцаат капитал /дүрмийн сан/-ын 25.2 хувийн өсөлтүүд тус тус голлох нөлөөг үзүүлсэн байна.

Тайлант хугацаан дахь зээлийн үлдэгдэл нь нийт активын 59.9 хувь, мөнгөн хөрөнгө 30.2 хувийг буюу нийт 90.1 хувийг эзэлж байгаа нь ББСБ-ын салбарын голлон эрхэлж буй үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа байгаа болохыг илтгэж байна.

## 2.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 6/

№	Ангилал	2011.03.31		2010.03.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
1	Хэвийн зээл	76,513,763.2	89.8%	54,764,824.7	87.7%	21,748,938.6	39.7%
2	Хугацаа хэтэрсэн зээл	2,639,116.6	3.1%	2,484,781.0	4.0%	154,335.5	6.2%
3	Чанаргүй зээл. Үүнээс:	6,016,951.6	7.1%	5,171,635.4	8.3%	845,316.2	16.3%
	а/ Хэвийн бус	1,901,342.6	2.2%	1,386,688.3	2.2%	514,654.2	37.1%
	б/ Эргэлзээтэй	1,005,863.9	1.2%	1,336,720.2	2.1%	-330,856.3	-24.8%
	в/ Муу	3,109,745.1	3.7%	2,448,226.9	3.9%	661,518.2	27.0%
<b>НИЙТ</b>		<b>85,169,831.5</b>	<b>100.0</b>	<b>62,421,241.1</b>	<b>100.0</b>	<b>22,748,590.3</b>	<b>36.4</b>

2011 оны 1 дүгээр улирлын тайлант хугацааны зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 36.4 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 2.1 хувиар өссөн бол, чанаргүй зээл 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

## ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-ын салбарын 2011 оны 1 дүгээр улирлын тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх онтой харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

/Хүснэгт 7/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2011.03.31		2010.03.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь



<b>A</b>	<b>Өр төлбөр</b>	<b>34,506,822.4</b>	<b>24.3%</b>	<b>24,903,580.0</b>	<b>23.3%</b>	<b>9,603,242.5</b>	<b>38.6%</b>
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	6,936,372.4	4.9%	5,395,174.6	5.0%	1,541,197.7	28.6%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	21,088,484.5	14.8%	14,449,819.6	13.5%	6,638,665.0	45.9%
3	Бусад эх үүсвэр	2,320,296.8	1.6%	1,213,845.3	1.1%	1,106,451.5	91.2%
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	0.0	0.0%	1,059.3	0.0%	-1,059.3	-100.0%
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,248,226.2	1.6%	1,208,885.4	1.1%	1,039,340.8	86.0%
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
	Факторингийн үйлчилгээний өглөг	8,607.8	0.0%	0.0	0.0%	8,607.8	#DIV/0!
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	63,462.9	0.0%	3,900.6	0.0%	59,562.3	1527.0%
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	400,000.0	0.3%	0.0	0.0%	400,000.0	#DIV/0!
5	Төслийн зээлийн санхүүжилт	3,761,668.7	2.6%	3,844,740.4	3.6%	-83,071.7	-2.2%
	<b>Бусад өр төлбөр</b>	<b>5,964,102.7</b>	<b>4.2%</b>	<b>2,822,321.6</b>	<b>2.6%</b>	<b>3,141,781.0</b>	<b>111.3%</b>
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,386,890.6	1.0%	369,682.9	0.3%	1,017,207.7	275.2%
7	Бусад пассив	4,577,212.1	3.2%	2,452,638.8	2.3%	2,124,573.3	86.6%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>40,470,925.1</b>	<b>28.5%</b>	<b>27,725,901.6</b>	<b>25.9%</b>	<b>12,745,023.5</b>	<b>46.0%</b>
<b>Б</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>101,704,588.0</b>	<b>71.5%</b>	<b>79,217,698.0</b>	<b>74.1%</b>	<b>22,486,890.0</b>	<b>28.4%</b>
9	Хувьцаат капитал	90,179,919.1	63.4%	72,011,587.7	67.3%	18,168,331.5	25.2%
10	Бусад өмч	2,223,299.4	1.6%	497,221.8	0.5%	1,726,077.6	347.1%
11	Сангууд	1,146,948.7	0.8%	1,123,616.8	1.1%	23,331.8	2.1%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	6,493,973.4	4.6%	4,723,557.8	4.4%	1,770,415.6	37.5%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	1,660,447.4	1.2%	861,713.9	0.8%	798,733.5	92.7%
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>142,175,513.1</b>	<b>100.0%</b>	<b>106,943,599.6</b>	<b>100.0%</b>	<b>35,231,913.5</b>	<b>32.9%</b>

Тайлант хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 46.0 хувиар, эзэмшигчдийн өмч 28.4 хувиар тус тус өссөн бөгөөд 2010 оны 1 дүгээр улирлын тайлант хугацаанд нийт эх үүсвэрийн 25.9 хувийг нийт өр төлбөр, 74.1 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2011 оны 1 дүгээр улиралд нийт өр төлбөр 28.5 хувь, эзэмшигчийн өмч 71.5 хувь болж өөрчлөгдсөн байна. Нийт эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь нэг талаас ББСБ-уудын хувьцаат капитал болон хуримтлагдсан ашиг өссөн, нөгөөтэйгүүр, ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ өссөнтэй холбоотой.

Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэр өмнөх оноос өссөн, өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

### ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2011 оны 1 дүгээр улирлын тайлант хугацааны нийт орлого өмнөх оны мөн үеэс 37.0 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 8/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.03.31		2010.03.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
	<b>ХҮҮГИЙН ОРЛОГО</b>	<b>6,034,898.1</b>	<b>69.6%</b>	<b>4,470,837.9</b>	<b>70.7%</b>	<b>1,564,060.2</b>	<b>35.0%</b>
1	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	5,580,895.6	64.4%	4,240,198.8	67.0%	1,340,696.8	31.6%
	Хугацаа хэтгэсэн зээлийн хүүгийн орлого	254,124.8	2.9%	151,342.3	2.4%	102,782.6	67.9%
	Үнэт цаасны хүүгийн орлого	0.0	0.0%	12,121.4	0.2%	-12,121.4	-100.0%
	Бусад хүүгийн орлого	199,877.7	2.3%	67,175.4	1.1%	132,702.3	197.5%
2	<b>ХҮҮГИЙН БУС ОРЛОГО</b>	<b>2,354,467.6</b>	<b>27.2%</b>	<b>1,725,481.6</b>	<b>27.3%</b>	<b>628,985.9</b>	<b>36.5%</b>
3	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>277,920.2</b>	<b>3.2%</b>	<b>122,656.9</b>	<b>1.9%</b>	<b>155,263.4</b>	<b>126.6%</b>
4	<b>ЕРДИЙН БУС ОРЛОГО</b>	<b>3,340.8</b>	<b>0.0%</b>	<b>7,968.0</b>	<b>0.1%</b>	<b>-4,627.3</b>	<b>-58.1%</b>
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>8,670,626.7</b>	<b>100.0%</b>	<b>6,326,944.4</b>	<b>100.0%</b>	<b>2,343,682.3</b>	<b>37.0%</b>

Ийнхүү нийт орлого өмнөх оны мөн үеэс 37.0 хувиар өссөн нь ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн өсөлт, бусдаас татсан эх үүсвэрийн өсөлттэй шууд холбоотой бөгөөд нийт орлогын өсөлтөд үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн орлого гол хувийг эзэлж байна.

Харин хүүгийн бус орлогын нийт орлогод эзлэх хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

/Хүснэгт 9/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.03.31		2010.03.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
1	<b>Арилжааны орлого</b>	<b>764,056.8</b>	<b>32.5</b>	<b>580,560.4</b>	<b>33.6</b>	<b>183,496.3</b>	<b>31.6</b>
1.1	Гадаад валютын арилжааны орлого	761,100.0	32.3	580,560.2	33.6	180,539.8	31.1
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	2,956.8	0.1	0.3	0.0	2,956.5	0.0
2	<b>Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого</b>	<b>1,063,743.3</b>	<b>45.2</b>	<b>769,644.0</b>	<b>44.6</b>	<b>294,099.3</b>	<b>38.2</b>
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	1,057,974.8	44.9	751,137.2	43.5	306,837.5	40.8
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	5,768.5	0.2	18,506.8	1.1	-12,738.3	0.0
3	<b>Санхүүгийн үйлчилгээний орлого</b>	<b>526,667.5</b>	<b>22.4</b>	<b>375,277.2</b>	<b>21.7</b>	<b>151,390.4</b>	<b>40.3</b>
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	0.0	0.0	168.6	0.0	-168.6	-100.0
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	0.0	0.0	19.7	0.0	-19.7	-100.0
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	131,730.0	5.6	102,490.0	5.9	29,240.0	28.5
3.4	Картын үйлчилгээний орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	21,237.2	0.9	18,740.0	1.1	2,497.2	13.3
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	288,181.0	12.2	128,522.0	7.4	159,659.0	124.2
3.7	Бусад	85,519.3	3.6	125,336.9	7.3	-39,817.6	-31.8
	<b>НИЙТ</b>	<b>2,354,467.6</b>	<b>100.0</b>	<b>1,725,481.6</b>	<b>100.0</b>	<b>628,985.9</b>	<b>36.5</b>



Тайлант үеүдийн хүүгийн бус орлогын бүтцийн хувийг харахад ойролцоо түвшинд байх ба уг бүтцэд төдийлэн өөрчлөлт гараагүй байна.

Харин нийт зардлын бүтцүүд дараах байдалтай байна.

/Хүснэгт 10/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.03.31		2010.03.31		Өөрчлөлт	
		дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь	дүн /мян.төг/	хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	813,029.5	10.8%	541,591.1	10.1%	271,438.4	50.1%
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	5,108,825.6	67.7%	3,893,429.8	72.7%	1,215,395.8	31.2%
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	1,246,256.0	16.5%	689,198.2	12.9%	557,057.9	80.8%
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	148,556.1	2.0%	38,633.2	0.7%	109,922.9	284.5 %
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	4,704.9	0.1%	24,781.7	0.5%	-20,076.8	-81.0%
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	220,831.0	2.9%	170,373.0	3.2%	50,458.0	29.6%
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>7,542,203.2</b>	<b>100.0</b>	<b>5,358,007.0</b>	<b>100.0</b>	<b>2,184,196.2</b>	<b>40.8</b>

Тайлант үеүдийн нийт зардлын бүтцэд мөн л төдийлэн өөрчлөлт гараагүй байна.

ББСБ-ууд нь 2011 оны 1 дүгээр улиралд нийт 1,128,423.5 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16.5 хувийн өсөлттэй байна.

/Хүснэгт 11/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2011.03.31	2010.03.31	Өөрчлөлт
		дүн /мян.төг/	дүн /мян.төг/	дүн /мян.төг/
1	НИЙТ ОРЛОГО	8,670,626.7	6,326,944.4	2,343,682.3
2	НИЙТ ЗАРДАЛ	7,542,203.2	5,358,007.0	2,184,196.2
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	1,128,423.5	968,937.4	159,486.1

### ТАВ. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын салбарын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 101,704,588.0 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 97,979,296.2 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд 101.8 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 103.8 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 70.1 хувь;

- түргэн борлогдох актив 44,710,522.1 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 26,846,294.2 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 166.5 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 5,641,855.9 мянган төгрөг, валютаарх өөрийн хөрөнгө 101,704,588.0 мянган төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 5.55 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 6,936,372.3 мянган төгрөг, хувьцаат капитал 90,179,919.1 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 7.7 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 2,057,727.4 мянган төгрөг, нийт актив 142,175,513.1 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.4 хувь байгаа нь салбарын хэмжээнд дээрэх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 4,610,176.7 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 29,756.7 мянган төгрөгөөр дутуу буюу нийт 4,580,419.98 мянган төгрөгөөр байгуулсан байна.

## **БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР**